



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/558

Хэрлэн сум


Хилийн 0287 дугаар ангид  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдааны 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.5.2 дахь заалтад заасны дагуу хилийн шугамын дагуу мөр хянах болон түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвасыг сэргээх үйл ажиллагаанд зориулж Хилийн 0287 дугаар ангид 3 000 000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ